

Хүн ба шим ертөнц (сэтгэл зүйн эсээ)

Будрагчаагийн Даш-Ёндон, доктор (Sc.D), профессор
Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс, dashyondonbudragchaa@gmail.com
<https://orcid.org/0009-0002-4306-8841>

Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-20

Published : 2024-12-20

Түлхүүр үгс

хүн,

шим ертөнц,

сэтгэл санаа

Keywords

the human,

fatness earth,

mind and wisdom

© The Author(s), 2024



Хураангуй: Шим Ертөнц, түүнд Хүн агаад хүний сэтгэл санаа холбогдох, үүний учир хүн сэтгэл санаагаа шинжихүйн асуудал өнөө цагт чухал утгатайгаар дэвшин гарч байна. Тиймээс сэтгэл санааны дотоод хэлхээ холбооны асуудлыг амьд байгальтай хамааруулан авч үзэж тайлбарлахыг зорилоо.

The human and fatness earth (psychological essay)

Dash-Yondon Budragchaa (Sc.D), Prof

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia, dashyondonbudragchaa@gmail.com

<https://orcid.org/0009-0002-4306-8841>

Abstract: The fatness of the earth that the human mind has to do with it and thus the problem of the analysis of the human mind is now developed in an important way. Consequently, it aims to consider and explain the problem of internal communication of the mind with regard to nature.

“Хангай дэлхий хэвээрээ атал

Хүний явдал их хувирсан”

Д.Нацагдорж

(«Түүхийн шүлэг»)

“Хүний явдал” хэмээх нь хүмүн бидний сэтгэл санааны асуудлыг хэлж буй нь ойлгомжтой хэрэг. Хүн болбаас шим ертөнцийн охь манлай билээ. Шим ертөнц буюу амьд байгалийн бүх дүрс, төрөл -үүдэд байдаг нийтлэг шинж нь махбодоос гадна сэтгэц гэмээр зүйл ажгуу. Энэ нь хүн дээр бол ухамсар, бусад амьтан агаад ургамал дээр бол амьдрах хүчний зөн совин

хэмээх зүйл боллолтой. Эл зөн совин нь хүнд бас бий. Шим ертөнцийн амьдран оршихуйн дотоод хэлхээ холбоо энэчлэн их нарийн ажээ.

Энэ дотоод хэлхээ холбоог харуулдаг гол зүйл нь **хөдөлгөөн** хэмээгч боллолтой. “Хөдөлгөөн бол матери оршин байх арга” (Ф.Энгельс) ажээ.

Эл бүхнийг бодолцоод хөндөж буй сэдвээ амилуулахын тулд Аристотелийн санааг дагуулан хэд хэдэн асуултаар баримжаалъя.

А. Шим ертөнцийн бүх амьтан хөдөлгөөнгүйгээр амь зууж чадах уу? Алив амьтан хэрэв хөдлөхгүй болчихсон бол амь-гүй болжээ гэсэн үг. Хөдөлж байх нь амь-тайгийн шинж бөгөөд амьдрах аргынх нь үндэс суурь юм.

Б. Тэгвэл, тэр хөдөлгөөн гэдэг нь юу вэ? Энэ хувьд, хөдөлгөөн гэдэг нь амьд махбод өөрөө, улмаар түүний эд эрхтэн байр солих үйл явц юм.

В. Харин энэ хөдөлгөөний эх сурвалж нь юу вэ? Амь-тайг хөдөлгөдөг зүйл нь тухайн бие дэх элдэв түвшний «сэтгэл» хэмээгч зүйл (энд орлох өөр үг олдсонгүй) бололтой.

Г. Энэ «сэтгэл» бүтэцтэй юу? Бөөн бүтэц: Хүний оюун ухамсар (дотроо олон задарна), адгуусны зөн совин, ургамлын “амьдарч буй өөрийнх нь өвөрмөц арга” гээд л ...

Д. Хүний ухамсрыг судлахад энэ бүхэн хамаатай юу? Энэ бүхнийг харгалзахгүйгээр хүний ухамсар, оюун ухаан, сэтгэл зүйг нарийн шинжлэх боломжгүй, яагаад гэвэл, хүн гэж юу вэ? (ухамсар бүхий амьтны хувьд) гэдгийг ямар нэг өөр байдлаар ойлгох аргагүй биз ээ.

Аристотель дэвшүүлэн тавьж, хариу хайсан энэ асуултууд, гол нь, түүний «Сэтгэл санааны тухай» (О душе)* зохиолд нь нэгдмэлээр хөндөгдсөн байна. Аугаа Аристотель бол сэтгэл судлалын ухааныг үндэслэгч мөн хэмээн хүлээн зөвшөөрөгдсөөр өдийг хүрсэн суутан билээ. Тэрбээр, дурдагдан буй зохиолдоо тухайн цагийнхаа, энэ хувь дахь, бусад философичдоос эрс өөр “өнцөг” гарган шинжжээ. Тэр “өнцөг” нь юу вэ гэвэл, “сэтгэл санаа”, сэтгэл санааны эх сурвалж бүх амьтан, ургамалд буй гэж үзсэнд оршино. Сав, шим ертөнцийг энэ үүднээс үзвэл зохилтой: байгаль

хамгаалалт үүн дээр тулгуурлах ёстой. Сав ертөнцгүйгээр шим ертөнц үгүй амой.

Нэвтэрхий эрдэмт Аристотель: “Сэтгэл санааг таньж мэдэх нь аливаа үнэнийг танихад, ялангуяа **байгалийг** (би онцлов, Б.Д.) ухааран ойлгоход ихээхэн түлхэц өгнө хэмээн бодогдож байна” (Аристотель. 2022 в, 35) гэжээ. Хүн, байгаль (амь-тай ч бай, амь-гүй ч бай)-ийн хоорондын хүй холбоог амьдрахуйн зайлшгүй нөхцөл, хөдөлгөөнөөр нь дамжуулан хэлж, хүн сүрэгт анхааруулж буйд энэ хэлснийх нь онцгой ач тус оршино. Ер нь, Аристотелийн энэ зохиол бол сэтгэл судлалын төдийгүй, **байгаль шинжлэлийн** сод бүтээл юм.

Тэрбээр, тус зохиолдоо: «Сэтгэл санааны тухайд бүхий л талаараа ямар нэгэн ойлгомжтой юманд хүрэх нь бүхнээс илүү хүнд хэцүү гэдэг нь маргаангүй» (Аристотель. 2022 в, 35) , «яагаад гэвэл, сэтгэл санааны тухай ярьж, түүнийг судалдаг хүмүүс зөвхөн хүний л сэтгэл санааг авч үзжээ» (Аристотель. 2022 в, 36-37) гээд “сэтгэл санаа”-ны асуудлыг амьд байгаль руу бүхэлд нь оруулан судалжээ. Энэ талаар дараалал гарган сонирхож үзье:

1. Амь ба сэтгэл санаа

Аристотель ухамсрын (одоогийн бидний нэр томъёогоор, Б.Д.) талаар судлахдаа амь агаад сэтгэл санааны дотоод хэлхээ холбооны асуудлыг судлахдаа сөхөн гаргаж тавьсан нь, тэр үедээ ч, одоо ч сэтгэл судлалын үүднээс онцгой чухал учир холбогдолтой юм гэдгийг түрүүнд хэллээ.

Юуны өмнө, амь гэж юу вэ? Энэ тухайд тэрвээр: « Амь - (жизнь)

гэдгээр, бид, өөрт нь цаанаасаа оногдсон үндсээсээ болж бие-үүд тэжээл авдаг, өсдөг, мөхдөг аливаа явдлыг нэрлэдэг билээ» (Аристотель. 2022 в, 74) гэжээ. Тэгвэл, манай монгол хэлэнд “амьдрал” (оросоор бол, мөн л “жизнь”) гэдэг хэллэг, ойлголт бас бий билээ. Энэ хоёр хэллэг, ойлголтыг хооронд нь жишиж байж аль алиных нь утгыг монголоороо ухаарах хэрэгтэй болно. Ингэвэл, жишээ нь, Аристотель нойрыг “амьд юм амь-тай, амь-гүй байгаагийн завсар хоорондын төрх байдал юм” (Аристотель. 1778, 29-30) хэмээн бичжээ. Энд “сэтгэл санаа”-ны тухай яригдаж байна. Энэ хэлснээс нь бодвол, “амь”, “амьдрал” гэсэн хоёр ойлголт, биднийхээр бол, ялгаатай хэмээн санагдаж байна. Тэгвэл, “амь”-ны хэрэгжилт, биелэл нь “амьдрал” бизээ. “Амь” үгүй бол “амьдрал” үгүй. “Сэтгэл санаа” үгүй бол “амь” үгүй. “Амь”, “амьдрал”-ыг судлахад “сэтгэл санаа” хамгийн чухал нь ажээ.

Тэгвэл, “сэтгэл санаа”-ны асуудалд хэрхэн хандах ёстой вэ? Аристотель үүнд холбогдуулж дараах сонирхолтой асуултуудыг дэвшүүлж хариу хайжээ. Тэр асуултууд нь:

- o Сэтгэл санаа хэсгүүдээс тогтдог уу, үгүй юу?
- o Бүх сэтгэл санаанууд нэгэн төрөл үү, үгүй юу?
- o Хэрэв нэгэн төрөл бусаа эсвэл тэдгээр нь өвөр хоорондоо дүрс юмуу төрөлийн алинаар нь ялгагддаг вэ?
- o Амьтны төрөл нэг бүрийн сэтгэл сэтгэл санааны тодорхойлолт нь нэг л байна уу? Эсхүл: адууны, нохойны, хүний, бурхны гэх мэтээр тус тусдаа тодорхойлолттой байна уу? (тус тусдаа өөр зүйл үү?)

- o Энэ нь амьд юмны тодорхойлолт нэг л байдагтай хэрхэн холбогдох вэ?
- o Хэрэв сэтгэл санааны нэгдмэл бүхэллэг гэж байдаггүй, сэтгэл санааны зөвхөн хэсгүүд л оршин байдаг гэвэл ямар ч гэсэн дараах асуултууд үүснэ: эхлээд сэтгэл санааг бүхэлд нь судлах гэж байх уу?, эсхүл түүний хэсгүүдийг судлах хэрэгтэй юу?
- o Эхлээд, хэсэгчлэн судлах ёстой гэвэл: хэсгүүдийн ямар ямар нь уг чанараараа өөр хоорондоо хэрхэн ялгагдах вэ?
- o Сэрэх чадвар агаад сэрэгдэхүүний алиныг нь эхэлж судлах ёстой вэ? (сэрэгдэхүүнийг нь үү?, сэрэх чадварыг нь уу?) гэх мэт.

Товчилбол, Аристотель ийм нарийн түвэгтэй асуултууд дэвшүүлэн судалсныхаа дүнд, тухай бүрт нь хариу өгсний дээр, эцэстээ «сэтгэл санаа бие-ээс гадуур юу ч мэдэрдэггүй», «сэтгэл санаа бие-ээс салангидаа оршин байж чадахгүй» (Аристотель. 2022 в, 38) гэсэн зарчмын томоохон дүгнэлт хийжээ.

2. Бие агаад сэтгэл санаа

Аристотель бие-ийг судлахдаа «бие бол сэтгэл санаа биш, бие өөрөө субстрат, өөрөө матери юм» (Аристотель. 2022 в, 74) гэсэн зарчмыг иш үндэс болгожээ. Энэ бол философийн уламжлалд ярьж дадсан *материалист* чиг баримжаа бүхий дүгнэлт юм. Аристотель энэ чиглэлээ нотлон баримталж, олон чухал санаа хэлжээ. Түүнийхээр, амь бол амьд бие-үүдийн бололцоо нь, харин сэтгэл санаа бол бие-үүдийн мөн чанар,

энтелехи* нь аж. «Иймд, сэтгэл санаа, бие хоёр ямар нэгэн нэгдмэл зүйл мөн үү? гэж асуух хэрэггүй», яагаад гэвэл, «энтелехи нь уугуул утгаараа нэгдэл агаад ахуй юм» (Аристотель. 2022 в, 75) гэжээ. Ингэхлээр, бие агаад сэтгэл санаа нь харилцан шүтэлцсэн нэгдэл, нэг мөн чанар юм. Амь-гүй *биет* дээр ийм зүйл яригдахгүй. Жишээ нь, сүх байг. Сүхэнд сэтгэл санаа гэж үгүй. Иймд сүхний мөн чанар нь сүх дангаараа л амой.

Аристотель ийм баримжаанууд гаргаснаа дагалдуулан «Амьдрах бололцоотой байгаа юм бол сэтгэл санаагүй зүйл биш, харин сэтгэл санааг эзэмдсэн тэр зүйл юм» (Аристотель. 2022 в, 76) гээд «сэтгэл санаа бие-ээс салгагдашгүй...хэрэв сэтгэл санаа уг чанараараа хэсгүүдтэй гэвэл сэтгэл санааны аль нэгэн хэсэг ч бие-ээс салгагдашгүй, учир нь сэтгэл санааны аль нэгэн хэсэг ч бие-ийн хэсгийн энтелехи (Аристотель. 2022 в, 76) юм» гэсэн байна.

Аристотель, бидний авч үзэж буй энэ зохиолдоо алив амьтны мэдрэхүйн эрхтэн бүрийн байдал, үүргийг тодорхойлоод, харин юмсын ерөнхий шинжийг тусгадаг жич эрхтэн байдаггүй хэмээжээ. Энэ тухайд тэрвээр, хөдөлгөөн, тайван, дүрс, хэмжигдэхүүн, тоон өгөгдөхүүн (үл тасалдахуйг үгүйсгэхийг тоон өгөгдөхүүн гэнэ, Аристотель), нэгдэл гэх зэрэг ерөнхий шинжүүдийг хуран мэдрэхэд зориулагдсан онцгой мэдрэлийн эрхтэн гэж байхгүй; яагаад гэвэл, мэдрэхүй бүхэн [сэрэгдэхүүний] зөвхөн нэг л төрлийг нь сэрж мэдэрдэг хэмээн бичжээ (Аристотель. 2022 в, 122).

Хэрэв ерөнхийг сэрж мэдрэх тусгай эрхтэн хүнд үгүй бол тэрхүү ерөнхийг нь сэтгэхүй, оюун ухаан л ухварлаж ойлгох үүрэгтэй биз ээ. Энэ талаар Аристотель, ухааны юмуу, ухварлах чадвар бол үзэл бодол боловсруулах чадвар юм, тодруулбал, сэрж мэдрэх гэдэг нэг хэрэг, үзэл бодолтой байх гэдэг нь өөр хэрэг хэмээн бичжээ (Аристотель. 2022 в, 79).

Энэ хэлж буйгаас нь үзвэл, хүмүний сэтгэл зүй мэдрэхүй лүгээ холбоотой, харин ерөнхийг ухварладаг ойлголт, үзэл бодол, онол, категори зэрэг танин мэдэхүйн ухагдахуунууд *сэтгэл судлал*-д хамаарахгүй ажээ.

Шим ертөнцийн тулаан дахь хүн

«Хүн амьтны түүх байн байн хувилсаар ирэх нь тэмцээний үр байжээ» Амьдрал бол тэмцэл. Амь-тай бүхэн амьдрахын төлөөнөө өөр хоорондоо ч туладддаг, сав ертөнцийн аугаа их хүчтэй ч тэмцэлддэг байна. Энэ тулаан бол амь булаацалдсан тэмцэл, ингэхлээр, хүнс тэжээл агаад орон зайгаа олж авахын төлөөх өрсөлдөөн юм. Энэ тулаан, тэмцэл, өрсөлдөөн нь шим ертөнц оршин байх арга ажээ. Тэмцэл, арга хоёр энэ тохиолд давхцму.

Хүн шим ертөнцийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг учраас мөн л ийм тэмцэл, өрсөлдөөний дунд аж төрдөг.

Энд, наад зах нь, дараах зүйлүүд орно:

а/ Сав шим ертөнцийн бүх баялгийг хүртэхийн төлөө хүмүүсийн хийдэг үйлдэл бол нэг ёсны тэмцэлдэхүй амой. Энэ тэмцэлд зөн совингийн ч, сэтгэл зүйн ч, ухамсар ухааны ч хөдөлгүүр оролцоно.

б/ Хүн төрөлхтний тэмцэлдэхүйн гол онцлог нь хөдөмөрт оршино. Хөдөлмөр бол шим ертөнц дэх ухамсартай үйлдэл бөгөөд

ашиглах төдийгүй бүтээх үйлс юм. хөдөлмөрөө хөнгөвчлөх арга замыг хайсан хүмүүсийн оролдлого оюуны агаад эдийн салбарт аугаа ихийг бүтээжээ.

в/ Хүний тэмцэлдэхүйн өөр нэг онцлог нь хүмүүс хоорондын тулаан юм. Энэ бол булаацалдахуйн тэмцэл. Эд хөрөнгө, эрх мэдэл, идэш хоол, газар нутаг – бүгдийг нь булаацалдму. Энэ булаацалдаан яван явсаар хүн төрөлхтнийг дайн гэдэг аюулт үзэгдэл рүү түлхэн оруулдаг байна. Дайн байлдаан бол хүнийг **амьтны нэгэн төрөл** мөнийх нь хувьд нарт ертөнцөөс устган арилгах аюулыг агуулж байдаг. Гэтэл шим ертөнцийн **амьтад** хэрэгтэй юмаа өвөр хоорондоо хичнээн булаацалдлаа ч бие биенээ дүрс төрлийн хувьд мөхөөдөггүй билээ. Ийм болохоор, улс, үндэстний хоорондын булаацалдахуй, өрсөлдөхүй, тэмцэлдэхүйд зохицуулалат хэрэгтэй. Зохицуулалтыг тэдгээрийн зэр зэвсэг бус, зөвхөн ухаан сэтгэл нь л хийх ёстой.

г/ Хүмүүсийн тэмцэлдэхүйд бас нэгэн онцлог буй: сэтгэлд ургадаг атаа жетөө, өшөө хорсол, гомдол эмзэглэл. Сэтгэл зүйн эдгээр үзэгдэл элдэв шалтгаантай боловч зохицуулалтыг нь мөн л оюун ухаан гүйцэтгэнэ.

3. Хүний сэтгэл дэх зөрчилдөөн

«Аяа, орчлон чи юу бодож байна? *Д.Нацагдорж* («Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе») Сэтгэл бол ухамсарлал дахь зөрчилдөөн. Дотооддоо зөрчил үгүйгээр хүний сэтгэл гэж үгүй. Яагаад гэвэл, хэрэв энд зөрчил үгүй бол хүний сэтгэл гэдэг нь ямар ч хөдөлгөөнгүй зүгээр л нэлийсэн ямар нэгэн зүйл болохсон билээ.

Энд их Аристотелийн нэгэн үгийг

иш татчихаад цаашилъя. Тэрвээр: «Үнэнч хайрын сэтгэл дотор үзэн ядахуй зүүрмэглэн суудаг» гэж бичжээ. Эл томъёоллоос ямар дүгнэлт хийж болох вэ? Хүний сэтгэлд өвөр хоорондоо нягт авцалдсан ил, далдын эерэг сөрөг талууд нуугдан суудаг ажээ. Ил буюу илэрхийлэл болж байгаа **эерэг** нь эвдэрвэл далд байдаг нь буюу **сөрөг** нь гадагшилна. Хүн хоорондын сэтгэлийн **эвдрэлцэл** эндээс үүснэ. Жишээ нь, алив хүнд нөгөө талтайгаа холбогдсон хайр, итгэл гэсэн үндсэн хоёр эерэг сэтгэл бий. Энэ хоёр нь холбогдох субъектийнхээ аль нэг талаас нь үл тоомсорлогдон эвдэгдвэл оронд нь дургуйцлийн бүх дүрс ил, далд ямарнэгэн байдлаар бий болдог аж.

Их Аристотель «*Уран илтгэхүйн ухаан*» (Даш-Ёндон Б. 2011 б) зохиолдоо Хүмүний сэтгэлийн байдал буюу сэтгэл зүйг: аз жаргал, сайн үйл, шударга ёс, ханамж, таатай байдал, оргилсон сэтгэл, уур хилэн, өршөөл, хайрлал, нөхөрлөл, дайсангал, аюухуй, ичихүй, ач тус, зэвүүрхэл, атаархал, өрсөлдөөн, янз бүрийн насны хүмүүсийн зан ааш гэх зэргээр ангилан нарийвчлан шинжиж үзжээ. Эдгээрээс аль нь сэтгэлийн эвдрэлцэлтэй, аль нь сэтгэлийн нөхөрлөлтэй холбогдохыг уншигч маань түвэггүй ялган харж чадах буйзаа.

Бас, эртний Грекийн их сэтгэгч Феофрастын «*Зан авир*» зохиолд (Даш-Ёндон Б. 2011 б) ухамсарлал, сэтгэлийн хүсүүшгүй 30 ааш авирыг харуулах хэмээсэн нь нэн сонирхолтой. Тухайлбал:

Тохуурхахуй, долигонохуй, дэмий чалчихуй, болхидож бүдүүлэгдэхүй,

таалагдах дурын бялдуучлахуй, жудаггүйгэхүй, дэмийрэн бурахуй, цуурхахуй, нүнжиггүй аашлахуй, шалиггүйтахуй, ёс алдахуй, дэгс хичээхүй, мулгуйтахуй, адайрлахуй, айдсаар сүжиглэхүй, донгиолон яншихуй, үл итгэхүй, балиартан заваардахуй, залхаан улиглахуй, алдар цууд горилохуй, харамлаж нарийлахуй, хоосон гайхуулахуй, давлиун загнахуй, хулчагнахуй, олигархид тал засахуй, залуу болж аяглахуй, гүжирдэн муулахуй, хүний мууд дурлахуй, ичгүүргүйгээр хомхойрохуй гэсэн янз бүрийн шинж янз бүрийн хүнд янз бүрээр илэрдэг ажээ.

Аристотель, Феофраст нарын ийм шинжилгээ нь хүний сэтгэл дэх зөрчилдөөнийг судлахад арга зүйн чухал ач холбогдолтой хэмээн санагдму. Энгэхүү хүсүүшгүй 30 ааш авирын нэг нь юуму хэд хэд нь нөгөө талын тодорхой хүн лүгээ холбогдон илэрвээс энд тухайн хоёр субъектийн хооронд сэтгэлийн эвдрэлцээн үүсэх нь мэдээж буй заа.

4. Сав ертөнц ба хүний сэтгэл

«Үхтэл орших төрөлх нутаг

Салж болшгүй орон мөн»

Д.Нацагдорж

Бид шим ертөнцийг хүнтэй холбогдуулан ярихдаа эл ертөнцийн маань өлгий болсон аугаа их Сав ертөнцийг орхигдуулах ёсгүй ээ. Хүний сэтгэл байгалийн үзэгдэлтэй хэрхэн холбогддогийг Д.Нацагдорж гойд сайхан харуулж бичжээ. Тэрвээр: *«Дөрвөн улирал»* шүлэгтээ улирал бүхэн хүний сэтгэлд хэрхэн нөлөөлдгийг харуулжээ:

Хавар болоход: хүний сэтгэл

тэнийж, “Хөгшин хүн өөрийгөө залуу болсон шиг санана”, нүүдлийн шувуу (галуу)-ны дуу сонсож малчин хүн уярна.

Зун болоход: “Залуу хүмүүсийн сэтгэл бие биеэ бодно”, “Хурдан морины яралзан ирэх нь хүн бүхний бахдал”.

Намар болоход: “Хөгшин, залуу хүмүүсийн сэтгэл бол бөн бөн бөн бөмбөрнө”, “Сэтгэлийн доторхи уйтгарт явдал хааяа хааяа бодогдоно”.

Өвөл болоход: уудам талд жинчин хүн дуулж, тасхийм ясхийм хүйтэнд монголын залуус нүүртээ цогтой, нүдэндээ галтай, хөгшид өвгөд галаа түлж хуучин үгсийг ярилцана.

Улмаар тэрвээр *«Анхны цас»* шүлэгтээ, цас хаялахад “хүн бүхний сэтгэлийн дотор тус тус нэг янзын дүр орно” гэжээ. Хэрхэн гүйцэх билээ!

Хүмүний баяр баясал ч, уйтгар гуниг ч, амьдрах хүсэл ч сав, шим ертөнцийн гоо сайхнаас эш авмой. Бидний гоо сайхны сэтгэлгээ ч сав, шим Ертөнцийн сүрт агаад гоо үзэсгэлэнт байдлаас эхтэй: цэцэг навч ч гоё, ой мод ч гоё, уул тал ч гоё, элсэн манхан ч гоё, гол мөрөн ч гоё, адгуус амьтан ч гоё, аадар бороо ч гоё, алтан нар ч гоё, аянга цахилгаан ч гоё, мөнгөн сар ч гоё, үүл солонго ч гоё бөлгөө.

Ер нь, байгаль дэлхий өөрөө дуу хуур амой. Гэлээ ч байгалийн сайхан нь хүний сайхныг Сайхан бүхэн баяр баясгаланг өдөөмү. Муухан бүхэн уйтгар гуниг төрүүлмү. Энэ хоёр мэдрэмж илэрч байх үедээ эсрэг тэсрэг мэт авч эцэс цаанаа салшгүй холбоотой. Өөрөөр хэлбэл, нэг нь нөгөөгөө илрүүлэн харуулдаг ажээ.

5. Мөнгө ба хүний сэтгэл

Мөнгө цагаан

Нүд улаан (Ардын зүйр үг)

Мөнгө хэмээх маань, уг нь, таваарын гүйлгээний хэрэгсэл болж үүссэн **эдийн засгийн харилцааны** түүхэн үзэгдэл билээ. Гэтлээ тэр нь хүний ухаан – ухамсар лугаа холбогдохоороо **сэтгэл зүйн категори** болчихдог байна. Ингэж хэлж буй минь мөнгийг жам ёсоор “сэтгэлийн гүйлгээ”-ний хэрэгсэл болдог гэсэн үг биш, харин мөнгө хүний сэтгэлд хэрхэн нөлөөлдөг “ид шид”-ийг судлах гэсэн хэрэг.

Энд, **таваар – мөнгө** гэсэн харилцааны зэрэгцээгээр **мөнгө – сэтгэл** хэмээсэн харилцаа гарч ирнэ. Хүний сэтгэлийг мөнгөөр үнэлдэггүй, мөнгөөр наймаалцдаггүй, хүний сэтгэлийг зарж борлуулдаг явдал үгүй. Тийм атал мөнгө – сэтгэл гэсэн асуудал юунаас үүсэж байна вэ? Энэ асуудлын үндэс нь **“мөнгөний увьдас”** болой. Увьдас нь юунд орших вэ?

Мөнгө байгаа бол хүний сэтгэлийг **амгалан** болгож чадму: амьдралын хэрэгцээт зүйлээ мөнгөөр олж авмой. Иймд түрийвч “хоолтой” бол эзэн нь тайван.

Мөнгө байхгүйгээрээ хүний сэтгэлийг **зовоож** чадна: түрийвч “хоосон” бол эзэн нь **түгшүүртэй**.

Мөнгө хүнийг байнгын **шаналгаанд** оруулж чадму: олдохгүй бол олохын шаналгаа, олсон бол хадгалж үржүүлэхийн шаналгаа. Өр болж шаналгах ч бий, авлага болж зовоох ч буй.

Мөнгө – сэтгэл хоёрын **ердийн** харилцаа иймэрхүү буюу. Гэтэл,

энд **ер бусын** харилцаа гэж бас гарч ирдэг байна. Авилга хэмээх хорт үзэгдэл, шунал хэмээх гайт сэтгэл хүний ухааныг ч сохолж мөнгө-ний захиргаанд эзнээ оруулдаг байна. Буруу гараар орсон, буруу гараар олдсон мөнгө хүнийг хариуд нь захиргаандаа авч, дэмийрсэн бардам дээрэнгүй ааш зантай болгодог ажээ.

Мөнгө бас эзнээсээ бусдыг ч захиргаандаа оруулдаг: энэ нь зээл, хүү хоёр юм. Уг нь мөнгө хүүхэд гаргадаггүй билээ. Гэтэл **зээлийн хүү** гэдэг “шударга” мөлжлөг мөнгөн дээр гардаг. Энэ нь мөнгөтэй субъектийн арга заль амой.

Хүний сэтгэл-д мөнгө-ний үзүүлдэг нөлөө энэ мэт ажгуу.

6. Сэтгэлээ шинжихүй дор

«Хүний сэтгэл эрх дураараа юмаа...

Муу биеийг эзлэн дагуулаад

*Мөн түүнийг төөрүүлэх ч магадгүй,
тэгшүүлэх магадгүй»*

Д.Нацагдорж.

(«Би хэн бэ, чи хэн бэ»)

“БИ” (ёжлолоор), нэг удаа, дээгүүр доогуур гүйж байгаад бага шиг албан газрын дарга болчихвоо, бага шиг бишээ, бүүр 5-6 ажилтантай гээч!

Тэгсэн чинь бүх юм, ялангуяа ажилтнууд маань нэг л жижиг “амьтад” юм шиг надад санагдаад байдаг боллоо: тэдэнтэй мэндлэх хэрэггүй, мэндлэхэд нь хариу хэрэггүй, ажил хэргээр ирсэн хүмүүстэй ч мөн адил – тэгж доош ороод яах юм бэ? Бас, бүх зүйлийг мэддэг, чаддаг юм шиг бодогдоод байх болов. Хэнийг ч тоохгүй, хэлгүй, дүлий юм шиг болчихлоо. Ингэж **аугаа ихийн дон** тусваа. “Дээшээ өгсөхдөө хүнтэй мэндэлж бай, доошоо буухад чинь гараа өгнө шүү” гэсэн үг байдгийг

мэдээгүйгээс би ийм байдалд оржээ.

“Цаас хэдүй нимгэн ч
Чичихээс нааш цоорохгүй
Хүн хэдүй ухаантай ч
Хэлэхээс нааш санахгүй”.

Ард түмний маань эл сануулга
үнэхээр онцгой, ухаантай, сургамжтай
ажээ.

Хүний сэтгэл алдарч болно,
тэгширч болно, аль алийг нь үзээд
өнгөрч болно. Дутах, гүйцэхийн
явдлаас энэ нь хамаардаг ажээ. Дутах
нь сэтгэлийг дундуур болгоно, гүйцэх
нь сэтгэлийг хангалуун болгоно.
Сэтгэл дундуур хэмээх нь зовиурын
ухамсарлал, сэтгэл хангалуун хэмээх
нь тааламжийн ухамсарлал.

Хулгай зэлгий хийж
Худал зөрүү ярьж
Хумхийн тоосыг ч үмхэх
Хомхой будангуй сэтгэл,

Энэ бол зовлонгийн үүд. Энэ үүд
дутуу-гийнх нь ажээ.

Улс нь хөгжиж
Үрс нь баясаж
Сайн нь биелж
Сайхан амьдрал бүтэх,

Энэ бол жаргалын үүд. Энэ үүд
гүйцэд-ийнх ажээ. Энд “баян”, “хоосон”
гэж яригдаагүй, харин сэтгэлийн
“хэмжээ”-г хэлж байна.

Мэдээж, хэн ч гэсэн сэтгэлээ
шинжиж болно. Сэтгэлээ шинжье
гэвэл, энэ насандаа хийж бүтээснээ,
хийж бүтээж буйгаа эрэгцүүлэгтүн,
тэгвэл ямар нэг ухварлал гарч ирж

Ашигласан материал

Аристотель. 2022 в. *Сэтгэл санааны тухай*.
ред. Чулуунбаатар Г. орч. Даш-Ёндон Б.
Улаанбаатар: Философийн хүрээлэн, ШУА.
Даш-Ёндон Б. 2011б. *Эртний Грекийн
философи сэтгэлгээний эх сурвалж*.
Орчуулгын ред. Чулуунбаатар Г. Vol. II

мэднэ.

Миний хувьд (ёжлолгүйгээр) гэхэд л:
Нэг мэдэхэд насан ахижээ,
Нээрээ юу билээ, эргэн бодохуйд:
Эх орныхоо төлөө юу бүтээв,
Ээж аавынхаа төлөө юу хийв.
Эхнэр хүүхдээ яаж асрав
Эрхэм нөхөддөө хэрхэн туслав
Эрдэм номд юу базаав.
Дандаа л дутуу.

Дутуу-гийн буруу нь хүсэл байсан ч
хүч хүрээгүйд бизээ хэмээн өөрийгөө
цагаатгаж сууна даа. Хамгийн гол нь:
Д.Нацагдорж: «Монголын төлөө гэсэн
сэтгэл

Бидний зүрхэнд уяатай» (Нацагдорж Д.
1980)

хэмээн монголчуудынхаа сэтгэлийг
илэрхийлсэн билээ. Бид энэ уяаг
сулруулах ёсгүй, харин ч улам чангалах
ёстой. Бид – Эх орныхоо үрс нь боловч
эх орон маань бидний хүүхэд билээ.
Иймд бид Эх орноо хүүхэд шигээ
хайрлах ёстой.

Эх орноо “зүрхэндээ уяж” чадаагүй
тийм хүмүүс эх орноо дээрэмддэг
байна, бас харийнханд дээрэмдэх
бололцоо олгодог, эсхүл ийм юмыг
зүгээр хараад суудаг, эсхүл хамтарч
нийлддэг ажээ. Ийм байдал бол зүй
бусаар баяжигчдын “зүрх” юм. Үүнийг
ях ёстой вэ?

Сүлд дуугаа эргэн эргэн судалж,
дуулагтун!

боть. Улаанбаатар: ФСЭЗХ, ШУА, “Соёмбо
принтинг” ХХК.
Нацагдорж Д. 1980. *Түүвэр зохиол*. Улаанбаатар.
Аристотель. 1778. *О вознисновении животных*.
Vol. V. 1 vols.